



**“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН “ШИЖИР-АЛТ” АЛТНЫ
ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000175

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2550466

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА	
ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	4
Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд	4
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ “ШИЖИР-АЛТ” АЛТНЫ ҮЙЛДВЭРИЙН ДРАГ УГААХ ТӨХӨӨРӨМЖ.....	5
ОРДЫН ГЕОЛОГИЙН ТОДОРХОЙЛОЛТ БА БҮС	8
Ордын газрын байршил	8
Цахилгаан хангамж	8
Усан хангамж.....	9
Хөдөлмөрийн нөөц.....	9
Байгаль орчны суурь үнэлгээ	9
Уур амьсгал	9
Хөрс	9
Ус	10
Гүний ус	10
Бохирдлын түвшин.....	10
Ордын уул геологийн тогтоц.....	10
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	25
Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	25
Биологийн нөхөн сэргээлт.....	26
Ногоон байгууламж.....	27
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	28
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	29
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	29
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	30
БОМТ-ийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	31
Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	32
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний тайлан.....	34
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	35
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл.....	36
ДҮГНЭЛТ	37

Төслийн товч танилцуулга

1. Уурхайн үйл ажиллагаа ба БОХНС талаар хийсэн ажлын мэдээлэл
2. Туул голын гольдрилын ордын товч мэдээлэл
3. 2025 оны БОХНС ажлын биелэлт БОХ -3 маягт
4. БО-ны нөхөн сэргээлтийн ажлын биелэлт
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. БОХНС-н төлөвлөгөө, орчны хяналтын хөтөлбөрийн биелэлт
7. БОХНС-н төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй мэдээ
8. 2025 оны БОХНС ажлын зардлын тооцоо
9. Ус ашигласны төлбөр, газрын төлбөрийн биелэлт
10. Нөхөн сэргээлтийн талбайн зураг
11. Дүгнэлт

ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд		
1.	Аж ахуйн нэгжийн нэр	“Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-н харьяа “Шижир-Алт” алтны үйлдвэр
2.	Улсын бүртгэлийн дугаар	9019029071, регистр 2550466
3.	Үйлдвэрийн нэр	“Шижир-Алт” алтны үйлдвэр
4.	Ордын нэр	Туулын гольдрил
5.	Ордын байршил	Нийслэл/хот/Аймаг
6.		Сум/Дүүрэг/
7.	Ашигт малтмалын төрөл	Алт
8.	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	175А
9.	Ашиглалт эхэлсэн огноо	1994 оноос
10.	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг /хот/
11.		Сум /дүүрэг /
12.		Баг/ хороо /
13.		Гудамж /байр
14.		Шуудангийн хайрцаг
15.		Утас
16.		Факс
17.		Гар утас
18.		Электрон шуудан
19.		Вэб хуудас
20.	Захирлын хаяг	Нэр
21.		Утас
22.		Факс
23.		Электрон шуудан
24.	ТЭЗҮ хийсэн огноо 175А лицензийн талбайд	2022 оны 11-сар
25.	Ашиглалтын хугацаа	8-н жил
26.	Жилийн олборлолтын хүчин чадал	1090 мян.м ³

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ “ШИЖИР-АЛТ” АЛТНЫ ҮЙЛДВЭРИЙН ДРАГ УГААХ ТӨХӨӨРӨМЖ

“Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын “Шижир-Алт” алтны үйлдвэр нь Туулын голын хөндийн алтны шороон ордын батлагдсан нөөцийн хүрээнд ашиглалтын ажлыг Драгаар угаах төхөөрөмжөөр явуулсан. Орд нь Төв аймгийн Заамар сумын Хайлааст баг Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг оршдог ба 1994 оноос олборлолтын ажлыг эхэлсэн.

Туул голын хөндийн алтны шороон ордод 1994-2011 онуудад Заамарын алтны үйлдвэр нь олборлолтыг явуулж геологийн батлагдсан 21 блокийн 20 блокыг ашигласан. Уулын бэлтгэл ажил хөрс хуулалтын ажлыг гидроэкскаватораар хийж гүйцэтгэх ба бэлэн болсон элстэй талбайд ус дүүргэж өвлийн улиралд элсийг нь хөлдөлтөөс хамгаалдаг. Усан хангамж нь битүү эргэлтийн усан сангуудаас хангагдах ба ус дундрах үед Туул голоос тодорхой хэмжээний усыг шахуургын тусламжтайгаар нөхнө. Ашиглалтын ажлын явцад голын гольдрил, уулын ашиглалт явуулах талбайн хооронд 200 метрээс доошгүй хамгаалалтын бүс үлдээж олборлолтыг явуулах стандартыг баримталдаг. Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй MNS-5917:2008, MNS-5918:2023 стандартын дагуу 2025 оны ашиглалтын жилд Тусгай зөвшөөрдийн хэмжээнд дотоод овоолгоор 66 мян.м³, гадаад овоолгоор 60 мян.м³ түрж тэгшлэн нийт 14,33 га-д техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлтийг 6,74 га-д хийсэн. Үүнээс 1,67 га, 3,84 га техникийн нөхөн сэргээлт, 6,74 га биологийн нөхөн сэргээлт нь Төв аймгийн Заамар сумын нутагт, 8,82 га техникийн нөхөн сэргээлт нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт харьяалагдана. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийг 58 мян.м³ 5,4 га талбайд хийж гүйцэтгэсэн энэхүү талбай нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт харьяалагдана.

**УУЛЫН АЖИЛ,ОЛБОРЛОЛТЫН УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН 2025 ОНЫ
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭ. МАЯГТ БОХ-3**

А. Хаягийн хэсэг.

Байгууллагын нэр	“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ийн харьяа “Шижир-Алт” алтны үйлдвэр
Аж ахуйн тусгай зөвшөөрлийн дугаар, регистр	2550466
Аймгийн нэр	Төв аймаг
Сумын нэр	Заамар “Хайлааст баг”
Орд газрын нэр	Туулын гольдрил
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-000175
Тусгай зөвшөөрлийн талбай	503.43 га
Ашигт малтмалын төрөл	Алт
Олборлох баяжуулах технологи	Драг

**Б. “Шижир-Алт” алтны үйлдвэрийн ордын нөхөн сэргээлт. Туулын
гольдролын орд Тусгай зөвшөөрөл-175А**

Үзүүлэлтүүд		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Гүйцэтгэл	
А		Б	В	Г	
Олборлолт эхэлсэнон		1	1994 он		
Олборлолт онд өртөх талбай					
Олборлолт явуулах тайлант 2025 онд	Олборлолтод өртөх газар	Гүн	2	м	5
		Талбай	3	га	17,5
		Эзлэхүүн	4	мян.м ³	1040
	Олборлолт явуулсан талбай	Өндөр	5	м	6.8
		Талбай	6	га	15,5
		Эзлэхүүн	7	мян.м ³	126,000
	Бусад	Гүн	9	м	-
		Талбай	10	га	-
	Олборлолт явуулах төлөвлөгөөт 2025 онд	Хийх газар	Гүн	11	м
Дотоод овоолго		Талбай	12	га	21
Бусад		Эзлэхүүн	13	мян.м ³	126,000
Техникийн нөхөн сэргээлт.					
Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	ТНС хийсэн газар	Талбай	14	га	451.1
		Эзлэхүүн	15	мян.м ³	-
	дотоод овоолго	Талбай	16	га	60,000
		Эзлэхүүн	17	мян.м ³	-
	Бусад	Талбай	18	га	-
		Эзлэхүүн	19	мян.м ³	-
Олборлолт явуулсан тайлант 2025 онд	ТНС хийсэн газар	Талбай	20	га	14,33
		Эзлэхүүн	21	мян.м ³	198
	дотоод овоолго	Талбай	22	га	10,5
		Эзлэхүүн	23	мян.м ³	60,000
	Бусад	Талбай	24	га	-
Олборлолт явуулах төлөвлөгөөт 2025 онд	Хийх газар	Талбай	26	га	-
		Эзлэхүүн	27	мян.м ³	-
	дотоод овоолгоор	Талбай	28	га	-
		Эзлэхүүн	29	мян.м ³	-
	Бусад	Талбай	30	га	-
		Эзлэхүүн	31	мян.м ³	-
	Биологийн нөхөн сэргээлт				
Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Нийт	Талбай	32	га	227.6
	Гад. овоолго	Талбай	33	га	-
	Бусад	Талбай	34	га	-
Олборлолт явуулсан тайлант 2025 онд	Нийт	Талбай	35	га	5
	дотоод овоолго	Талбай	36	га	5
	Бусад	Талбай	37	га	-
Олборлолт явуулах	Хийх газар	Талбай	38	га	5
	Гад. овоолго	Талбай	39	га	-
	Бусад	Талбай	40	га	-

**“ТУУЛ ГОЛЫН ГОЛЬДРОЛ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

төлөвлөгөөт 2025 онд				
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө				
Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	41	сая төг.	102,500,000	
Олборлолт явуулсан тайлант 2023 онд	42	сая төг.	20,000,000	
Олборлолт явуулах төлөвлөгөөт 2025 онд	43	сая төг.	20,000,000	
Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан хөрөнгө				
Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	44	сая төг.		
Олборлолт явуулсан тайлант 2023 онд	45	сая төг.	320,025,000	
Олборлолт явуулах төлөвлөгөөт 2025 онд	46	сая төг.	50,000,000	
Үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд-2025 онд				
Хөрс хуулалт	Талбай	47	га	15
	Хэмжээ	48	мян.м ³	696.3
Хүдэр олборлолт, элс угаах	Талбай	49	га	11.9
	хэмжээ	50	мян.м ³	803.1
Бүтээгдэхүүн гаргалт	51	кг	6.498	
Олборлолтод ашиглах ус				
Усны төрөл	52	Гадаргуун ус		
Хэмжээ	53	мян.м ³	560526.0	
Химийн хортой, аюултай бодисын зарцуулалт.				
Зөвшөөрөгдсөн хэмжээ	54	кг	-	
Зарцуулсан хэмжээ	55	кг	-	
Олборлолтод өртсөн ойн бүрхэвч				
Талбайн хэмжээ	56	га	Үгүй	
Нөөцийн тоо хэмжээ	57	м ³	Үгүй	

Тайлан гаргасан:

“Шижир-Алт” АҮ-ийн
БО хариуцсан мэргэжилтэн

Б.Одончимэг

“Шижир-Алт” АҮ-ийн
Маркшейдер

Б.Төврагчаа

ОРДЫН ГЕОЛОГИЙН ТОДОРХОЙЛОЛТ БА БҮС

Ордын газрын байршил

Засал захиргааны байршил- Туул голын алтны орд нь Төв аймгийн Заамар сумын нутаг Булган аймгийн Бүрэгхангай сумын хил дээр Улаанбаатар хотоос баруун хойш 240 км, Заамар сумын төвөөс хойш 30 км зайтай өргөрөгийн 48°18′, уртрагийн 108°18′ –д оршино. Хамгийн ойрхон аж үйлдвэрийн төвүүд нь Булган хот баруун хойш 100км, Эрдэнэт хот 90 км, Дархан хот зүүн хойш 180 км-д тус тус оршино. Энэ хотуудтай тус орд нь шороон замаар холбогдоно. Лүн сумаас Улаанбаатар хүртэл 120 км цардмал замтай. Ордоос ойролцоогоор 80 км-т Дархан –Эрдэнэтийн төмөр зам, Орхон –Туулын өртөө байна. Орд нь Туул голын өмнөөс хойшоо эргэсэн булангийн баруун эргийн өргөн хөндийд хойшоо чиглэлтэй сунаж тогтсон, нийт урт нь 11800 м өргөн нь 80-1205м байна.

ГАЗАР ЗҮЙ- Газар нутаг нь далайн түвшнээс дээш 800-1000 м хүртэл өргөгдсөн байна. Орд газрын зүүн талд Заамарын нуруу зүүн хойноос баруун урагш чиглэн байрших бөгөөд түүний хамгийн өндөр цэг нь Заамар уул далайн түвшнээс дээш 1816,2м өндөр ажээ. Энэхүү нуруунд Цогт 1384,6м, Заамарын цагаан овоо 1560,3м, Авдрантын овоо 1776,4м Халзан уул 1715,2м гэх мэт толгодууд байхаас гадна туул голын зүүн эрэгт Давхар овоо, Өгөөмөр овоо, Цагаан булагийн өндөрлөг, толгодоос эх авсан Баянгол, Цагаан булагийн өндөрлөг, баясгалан овоо гэх мэт 90-1100м хүртэл өргөгдсөн өндөргүүд оршино. Эдгээр уул толгодоос эх авсан Баянгол, Цагаан булаг, Тосонгийн гол зэрэг жижиг гол горхи усан Туул голд юүлнэ. Ер нь газар зүйн энэ тойргийн хэмжээнд чийг тунадас ховор учраас дотроосоо эх авсан гол горхи цөөн жижиг гол горхинууд нь дундаа буюу эсвэл адагтаа хатдаг байна. Туул голын хөндийн өргөн зарим газраа 10 км хүрнэ. Ийм хөндий эртний гаралтай бөгөөд сүүлийн үед тектоник хөдөлгөөн зэрэг шалтгаанаар усгүй болсон ажээ. Энэхүү толгод хөндий нь бага Хэнтий нь гол нуруутай холбоотой. Энэ хавийн газар нутгийн хотгор, гүдгэр төрх байдлаараа усны идэгдэл салхины өгөршлийн үйл явцад геологийн урт хугацаанд нөлөөлсөн шинжтэй. Хотгор гүдгэрийн үндсэн хэв шинжүүдийн хувьд бэсрэг уулын хэв шинжид багтана. Иймд уул толгодын орой хавтгай бөмбөгөр хажуу нь ялангуяа Заамарын нурууны баруун хажуу нилээд налуу болно. Хотгор гүдгэрийн хэлбэр дүрс дөрөвдөгч галавын үед гадаад дотоодын хүчин хавсарсан үйлдлээр бүрэлдсэн тул 2 сая гаруй жилийн хугацааны түүхтэй эртний хөндий юм. Хүйтний улиралд их хүйтэрдэг. Олон жилийн цэвдэгт хөндий тархацаар энэ нутаг Монголын II бүлэг буюу алаг цоог тархсан хэсэгт хамрах бөгөөд үндсэндээ цэвдэг хөрс 3-15 м хүрнэ.

Туул голын алтны орд нь Монголын эдийн засгийн төв районд орших Заамарын алтны бүлэг ордын тоонд орно.

Цахилгаан хангамж

Эрчим хүчийг Зүүнхараа-Жаргалан –Угтаалыг дайран өнгөрөгч ЛЭП -10кВт –ын шугмаас салбарлан авна. Дулаан гаргаж авахад Багануур, Налайх, Баян -

Тээгийн ордын нүүрсийг ашиглана. Өвөрхангай аймгийн Баянтээгийн нүүрсийг автомашинаар зөөвөрлөж уурхайн тосгоныг дулаанаар хангана.

Усан хангамж

Уурхайн тосгоны хүн амын ундны хэрэгцээг Туул голын баруун цутгалан болох Ар наймган, Хайлааст голын уснаас илүү чанартай гүний цооногоос ус гаргаж хангана. Энэ ус нь 10-40м-ийн гүндаллюви-пролювийн хурдаст агуулагдах бөгөөд ундарга нь 1л/сек болно. Харин техникийн хэрэглээнд Туул голын ус хангалттай.

Хөдөлмөрийн нөөц

Заамарт 1994 оноос эхлэн Туул голын хөндийд хувийн болон улсын чанартай 40-оод аж ахуйн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Ийм учир мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан. Нутгийн иргэд мал аж ахуй, газар тариалан эрхэлж байсан боловч уурхайнууд ашиглалтанд орсноор залуучууд нь шинээр мэргэжил эзэмшин ажиллах бололцоотой болсон. Заамар сумын төв дэхь Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн төвд байнга бульдозерчин, алт угаагчийн дамжаа хичээллэж мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж байсан.

Байгаль орчны суурь үнэлгээ

Монгол орны геоморфологийн мужлалаар Заамарын алтны орд газар нь Хангай Хэнтийн уулт өндөрлөгт багтана. Иймд бэсрэг уулс, хотгор гүдгэр газар нь харьцангуй бага газрыг хамран оршино. Физик газар зүйн хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн захын тойрогт багтана.

Уур амьсгал

Гидрогеографийн сүлжээнд Туул голын сав газарт багтах ба ордын район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Ерөнхий уур амьсгалын мужлалаар хуурайдуу сэрүүн зунтай, хүйтэн хахир өвөлтэй. Тухайн нутгийн агаарын жилийн дундаж температур -2,1 хэм, ууландаа -2,0 хэм байдаг нь голын хөндийд өвлийн улиралд хүйтэн агаарын хөдөлгөөн багатай жиндүүлэх нөхцөл эсрэг циклонлог цаг агаарын үйлчлэл юм. Хамгийн хүйтэн үе нь 1-р сард агаарын дундаж температур 21,0 хэм, өвлийн үнэмлэхүй ба хамгийн их температур -39,0 хэм хүрнэ. Хамгийн дулаан үе 7-р сард агаарын дундаж температур орд орчимд 18 хэм, ууландаа 1-2 хэм сэрүүснэ.

Хөрс

Туулын хэсгийн алтны орд газар нь байгаль цаг уурын бүсчлэлээр Монгол орны хээрийн бүсэд багтах бөгөөд нутаг дэвсгэрийн ихэнх хэсэгт хөнгөн ба дунд шавранцар, дунд зэргийн зузаантай хүрэн хөрс, уулын хүрэн хөрс, багахан хэсэгт нь нугын хээржсэн ба хужирлаг, улирлын цэвдэг хөрс, маш бага хэсэгт аллювийн нугын хөрс тархана. Ер нь намгархаг талбайтай. Энэ хэсэгт хөрсний бохирдол байхгүй.

Ус

Дүүргийн гол усан хангамж Туул гол нь Орхон голын баруун цутгал болдог. Туул гол зүүн хойноос чиглэлтэйгээр бүх талбайг туулж өнгөрдөг. Ерөнхий урт нь 600 км, хөндийн өргөн 1-4 км-т хэлбэлзэж байдаг. Гольдролын тахиралттай хэсгүүдэд олон тооны арал ба цутгалтай. Гольдрилын өргөн 30-100м, гүн нь 0,5-1,6м зарим газраа 2м, хурд нь 0,3-1,1 м/сек. Хөндийн налуу 0,001-0,002. Ордын хязгаарт гольдрилын үнэмлэхүй тэмдэгт нь 936,7-938,7м. Ордын хэсэг Туул гол зүүн гар тийш гурван, баруун гар тийш дөрвөн томоохон тохой үүсгэнэ. Эдгээр тохойрсон хэсэгт гол татмын дээрх дэнжид, заримдаа уулын хормойд /Өгөөмөрийн ард/ тулж усрах бөгөөд тохойрсон талдаа өндөр эгцэрэг үүсгэнэ. Эдгээр байдлаас шалтгаалан энэ хэсэгт нутгийн оршин суугчдын яриагаар Туул голын ус татам дээгүүр хальж үерлэх явдал бараг ажиглагагүй болно. Усны бохирдолтын хувьд стандартаар тогтоосон хэмжээнээс бага байгаа бөгөөд зөвхөн хаврын улиралд шар усны үеэр Улаанбаатар хот болон урсгалын дээр бусад үүсвэрүүдээс хатуурсан бохирдол тархах явдал ажиглагддаг. Дэнж нь ихэнхдээ намгархаг. Харухайн гол нь зүүн хойноос чиглэлтэй урсаж Туул голын зүүн цутгал болдог. Түүний хөндий нь өргөн, балчиг намгархаг, Баянголын хагарлын заадсын хэсэг бүгд хамаарна. Гольдрилын өргөн нь 5-10м, гүн нь 1,5м, дунджаар 0,5м усны түвшин нь хур тунадаснаас их хамаардаг. Усны өөр чухал цутгал нь Тахилтын гол, Бичигтийн гол, Хайлааст, Баянгийн гол эдгээр нь Туулын цутгал болдог. Нурууд нь уулс хоорондын хөндий Заамарын хөндийд байрладаг. Уурхайн ажиллагааны явцад Туул голын үндсэн гольдрил /2,5км/ бүрэн өөрчлөгдөх магадлалтай. Хөрс хуулалт олборлолтын явцад гадаргын усны чанар, хэмжээнд өөрчлөлт орно. Иймд нарийвчилан авч үзэж голын усыг булингартахаас хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.

Гүний ус

Гидрогеологийн судалгаанаас авч үзэхэд хөрсний ус 2,5-3м гүнд байна. Уурхайн гүнзгийрэлтийн хэмжээ 3-10м болно. Иймд уурхайн ашиглалтын үед гүний усны хэмжээнд өөрчлөлт ордог. Эдгээр өөрчлөлтийг хянах шаардлагатай.

Бохирдлын түвшин

Орд газрын нутаг дэвсгэр нь байгалийн онгон цэврээрээ байгаа бөгөөд нутгийн ард иргэд зөвхөн зун намар бэлчээр байдлаар ашиглаж ирсэн тул алтны уурхай байгуулахын өмнө орчны төлөв байдлын зургийг гар, фото, видео байдлаар авч хадгалан ашиглаж дууссны дараа энэ байдалд нь оруулан нөхөн сэргээлт хийлгэх шаардлагатай.

Ордын уул геологийн тогтоц

1.2.1. Урьд хийгдсэн геологийн судалгаа

Туул голын урсгалын доод хэсгийн шороон дахь алтжилт нь алт эрэгчдийн сонирхолыг эрт дээр үеэс татаж байсны үлдэгдэл ул мөр нь Туул голын дэнж дээр Баянгол, Цагаанбулаг, Уртсайр, Тосонгийн голын ам зэрэгт илэрдэг боловч судлаачдын ашиглалтын материал үлдэж хоцроогүй байна.

1950 оны сүүлээр тус районы геологийн тогтоцыг судлах ажил эхэлж 1:1000000 масштабтай геологийн зураг зохиосон / В.А.Ботезат, Ю.М. Арсеньев,1958/.

1971 онд 1:200000 масштабтай геолог-эрлийн ажил В.М. Якимов,П.Б.Ламатханов, А.Баатар нарын удирдлагаар явуулсан.Энэ ажлаар Заамарын нурууны баруун болон баруун-хойд хэсэг хүдрийн болон шороон ордны алтны хувьд ирээдүйтэй гэж үнэлэгдэж нарийвчилсан эрлийн ажил явуулах талбайг ялгаж өгсөн.

1973-1975 онуудад ГУУҮЯ –ны харьяа ГУШЧ-ийн дэргэдэх ангийг сэдэвчлэх ажилтнууд Хойд Хэнтийн алтны бүсийн алтны байршлын зүй тогтлын талаар 1:500000 масштабтай металлогений судалгаа хийж Заамарын районы шороон ордуудад таамаг нөөцийг 5-7 тн гэж тогтоожээ./Т.Семейхан, В.Поздняк/.

1979-1981 онуудад Дарханы геолог хайгуулын экспедицийн Заамарын анги 1:50000 масштабтай геолог-зураглалын ажлыг Туул голын урсгалын доод сав газарт хийж гүйцэтгэсэн./Д.Жамцаа, В.Довжид, А.К.Извяков, 1981 он/. Шлихийн сорьцлолт болон эрлийн шурфийн үр дүнд Туул голын баруун хэсгийн гольдрилын хурдсаны хэмжээнд болон Хайлааст, Халзан, Баянгол, Цагаанбулаг, Урт сайр зэрэг голуудын хөндийд алтны агуулга мөн тогтоогдсон.Эдгээр алтны шороон илрэлүүд нь структурын хувьд Заамарын антиклинальтай давхацдаг.Зохиогчид районы нийт нөөцийг 15,4 тн хэмээн үнэлжээ.

1981 онд дарханы геолог хайгуулын экспедицийн ажлын үр дүнд дахин Туулын ангийг байгуулж Туул голын хөндий болон түүнд цутгагч бага Хайлааст голын адагт эрлийн өрмийн ажил хийгдсэн. Цохилотт өрөмдлөгийн аргаар үйлдвэрлэлийн агуулга бүхий 14 шороон ордыг нээсэн.Энэ ажлын үр дүнд Монголд хамгийн том ирээдүй бүхий алтжилтийн бүсийг тогтоож Заамарын районд алтны шороон ордуудын хэмжээнд нийт нөөцийг 74,9 тн гэж үнэлгээ өгсөн./В.Довжид, А.Н.Кирсанов нар 1984 он/.

1983-1985 онуудад Туул голын хөндийд Дарханы экспедицийн зэрэгцээ ГУУҮЯ-ны харьяа Төвийн геологийн экспедицийн Жанчивлангийн анги Бага Хайлааст, Дунд голуудын хооронд ажиллаж байсан. Энэ анги цохилотт өрөмдлөгийн ажлаар Туул голын гольдрилын хурдсанд 350-650 м-ийн өргөнтэй үйлдвэрлэлийн агуулга бүхий алтжилт байгааг тогтоосон ба энэ нь “Туулын полигон” болно.

1982-1985 онуудад “Хойд Хэнтийн “ металлогений бүсийн баруун өмнөд сэдвээр шороон орд ба үндсэн эх үүсвэрийн хоорондын холбоо, бүрэлдэх нөхцлийг тогтоох судалгаа хийсэн./Н.Я.Шаболовская, Т.Пүрэвдорж, Г.Дэжидмаа ,1984 он/.

1985 онд Дарханы геолог хайгуулын экспедицийн Туулын анги Хайлааст голын хөндийд нарийвчилсан хайгуулын ажил хийж Монгол Улсын нөөцийн комиссоор 6 тн алтны нөөц батлуулж үйлдвэрлэлд шилжүүлсэн. Мөн энэ онд “Монголросцветмет” нэгдлийн “Толгойт”-ын хэсэг ордын нэг блокод туршилтын ажлыг эхлүүлсэн.

1986 онд Дарханы экспедицийн Угтаалын анги Заамарын районы хойд хэсэгт 1:50000 масштабтай геолог зураглалын болон алтны үндсэн ордын эрлийн ажил хийсэн.

Энэ ангийн ажлын үр дүн нэлээд хэдэн алтны илрэл тогтоосон ба мезозойн настай конгломерат дахь алтжилтанд үнэлгээ хийсэн.

1987 онд Туулын анги “Баянголын полигон”-д нарийвчилсан хайгуулын ажил явуулж ЗХУ ын болон БНМАУ -ын нөөцийн комиссоор 18 тн нөөц батлуулсан. Үүний 12,5 тн нь ил аргаар .5,5 тн-ийг драгын аргаар олборлоно.

1986 онд хоёр улсын хоорондын гэрээ /гэрээ 55-010/672, нэмэлт 17.19-5.06.81/ байгуулагдаж Туул голын хөндийд Бага Хайлааст голоос дээш хэсэгт Зөвлөлтийн геологийн экспедицийн Заамарын геологи хайгуулын анги алтны шороон ордод хайгуулын ажил гүйцэтгэсэн. 1987 онд “Туулын полигон”-ы хойд хэсэгт урьдчилсан хайгуул хийж 13858 кг алтны нөөц болсоны С₁-7575 кг, С₂-6282,9 кг болно. 1988 онд Зөвлөлтийн геологийн экспедиц энэ хэсэгт нарийвчилсан хайгуулын ажил хийсэн /878-986 хайгуулын шугамын хооронд/

ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

А. Орчны хяналт шинжилгээ, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах техникийн арга хэмжээнүүд:

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга зам.

Туул голын гольдрилын ордыг ашиглах үед агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Төслийн бүхий л үйл ажиллагааны явцад тоосжилтыг хянах бууруулах үр ашигтай бөгөөд практик ач холбогдолтой журмыг боловсруулан мөрдөж ажилласан.

Уурхайн дотоод зам болон тоос шороо босох ил задгай талбайнуудыг байнга услах, хайрга дэвсэх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тохируулгыг байнга хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандарт шаардлагын хэмжээнд байлгана.

Эдгээр орчны хяналт шинжилгээний ажиллагаанууд мэргэжлийн хяналтын газрын лабораторитой хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хийгдсэн.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хамрах
хүрээ

№ Байгаль орчныг
хамгаалах арга
хэмжээ

Хийгдсэн ажил

Биелэлт

1. Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах



Уурхайн хүнд даацын машин техникийн технологийн зам, дотоод тээвэрлэлтийн зам шинээр үүсгэх тохиолдолд зам маршрутыг нарийвчилан төлөвлөж зурагт тусгадаг бөгөөд зам тавихдаа шимт хөрсийг хуулан авч хэлбэржүүлэн, үйлдвэрлэлийн хаягдал болох эфель, гааль зэргээр хучиж, сайжруулалт, арчилгааг тогтмол хийснээр бүх машин техникүүд тогтсон зассан замаар явж хөрс эвдэх, тоос үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

20 тонн Хово автосамосвалын тэвшийг өөрчлөн технологийн замын усалгааг өдөр бүр 2-3 удаа хийсэн. Мөн нэмэлтээр тунаах нуурнаас шууд ус авахаар нэмэлт цорго хийж хурдан ус авах, олон удаа услах давтамжийг нэмэгдүүлсэн.

Агаар орчин

2. Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмол хийх хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах.



3. Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавих



4. Дуу шуугианы хэмжилт хийлгэх, дуу шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй



Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын итгэмжлэгдсэн лаборатороор 5 дугаар сард орчны хяналт шинжилгээ, хэмжилт хийлгэсэн. БОАЖЯ-ны дэргэдэх Судалгаа шинжилгээний албаны лабораториор 22 цэгээс хөрс, ус, агаар, дуу чимээний шинжилгээ хийлгэсэн. Лабораторийн шинжилгээний дүнгээр үзүүлэлтүүд хүлцэх агууламжаас хэтрээгүй хэвийн хэмжээнд гарсан. Мөн ХАБЭМТ эрсдэлтэй ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2025.10 сард хийлгэн сөрөг нөлөөллийг бууруулан ажилласан.

Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай хуучин техникуудийг сэлгэн тайлант онд 6 ширхэг техник шинээр ашиглаж байна.

Булган аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газраар 5 сард орчны хяналт шинжилгээний хэмжилт хийлгэсэн. Дүгнэлтээр хүлцэх агууламжаас хэтрээгүй хэвийн хэмжээнд байсан.

Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулахаас сэргийлж уурхайн үйл ажиллагааг 2 км зайтай байрлуулан ажилласан.



6. Зуны улиралд үер бууж, уурхайн овоолго зам талбай усанд автаж болзошгүй учир үерийн уснаас хамгаалах хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх арга хэмжээ авч шуудуу, хамгаалалтын далан барих



Лаг бохирдлыг байгальд шууд хаяхгүй байх зорилгоор бохир соруулах машинаар улиралд 1 удаа бохирыг соруулан авч зориулалтын цэгт устгаж байна.

Манай үйлдвэрийн байрлаж буй Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн төвийг үерийн усанд автуулахгүй байх үүднээс мэргэжлийн түвшинд үерийн шуудуу /1200 диаметртей/ хоолой хийснээс хойш хугацаанд тухайн багт үер ороогүй үр дүнтэй ажил болсон бөгөөд шуудуу, хоолойг улирал бүр цэвэрлэн сэргээж байна. Хамгаалалтын далан, шуудууг барьж орон нутагт хүлээлгэн өгсөн.

Хөрсөн
хэвлий
бүрхэвч,
газрын

7. Байгалийн гэнэтийн эрсдлийг урьдчилан тооцох, хохирол учирсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах хөтөлбөр боловсруулах



БОННУ тайланд үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, авах арга хэмжээний зөвлөмж өгсний дагуу арга хэмжээ авч ажиллаж байна.

ХАБ-тай хамтран Аваарын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын газраар батлуулан ажилласан.

8. Тээврийн хэрэгслийг зөвхөн баталгаажуулсан замаар явуулж байх, маршрутын бус замаар явахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээ тавьж өгөх



Тээврийн хэрэгслийг зөвхөн баталгаажуулан тогтоосон замаар явуулан, хориглосон тэмдэг тэмдэглээ тавьж өгсөн.

9. Өнгөх хөрсийг хуулан авах уурхайн үйл ажиллагаа эхлэх үед өнгөх хөрсийг хуулж шимт хөрсийг овоолох



Шимт хөрсний овоолго үүсгэн, стандартын дагуу хадгалж, дараа жилийн биологийн нөхөн сэргээлтэд хэрэглэж байна.

10. Шатах тослох материалыг зориулалтын саванд хадгалах, уурхайн орчимд асгарч алдагдахаас сэргийлэх



4 хэсгийн ажлын байруудад шатах тослох материалаар бохирдсон бээлий, даавууг ялган ангилж байна.

Асгаралтын иж бүрдлийг Драг ил уурхайн хэсэгт тараан өгч тос маслыг шингээн авч зориулалтын саванд хийж байна.

11. ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хайргажуурах, газрын гадарга хөрс бохирдохоос сэргийлэх



Засварын талбайг цементлэн тэмдэгжүүлж, хогийн сав байршуулсан. Засварын талбайг байгалийн хатуу хучилтаар шийдсэн. Үүнд: урьдчилан шимт хөрсийг хуулан авч гааль болон эфелээр хучилт хийн дагтаршуулж хөрсөнд асгарсан тос, масло шингэхгүй байхаар болсон.

Мөн хөрсөнд тос, масло асгарсан тохиолдолд хор саармагжуулах бодисыг ашиглан хоргүйжүүлж байна. Хөрсөн бүрхэвчийг доройтуулахгүйн тулд тамхины ишийг ил задгай хаяхгүй байх нөхцлийг бүрдүүлж тамхины иш цуглуулах зориулалтын савыг цех хэсэг бүрт байрлуулан ашиглаж байна.

Мөн ашиглаад дууссан принтерийн хорыг цуглуулан мэргэжлийн байгууллагад тушаан устгалд оруулсан. Хөрсөнд химийн хорт хаягдал хаяхгүй байх зорилгоор ашиглаж дууссан зай /баттерей/-г цуглуулах савыг өөрийн үйлдвэрийн цех хэсгүүд дээр байршуулан ашиглаж байна. Мөн Төв аймгийн 27 сумын төрийн байгууллагуудад тараан өгч уриалга гарган ажилласан.



12. Талбайн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх



Том оврын хог хаягдлыг цуглуулан хөрсийг хамгаалан асгаралтын иж бүрдэл жолооч нарт ашиглуулж байна.

Ургамлан нөмрөг

13. ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хайргажуулах, ургамлан нөмрөгийг бохирдохоос сэргийлэх



ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хайргажуулж хатуу хучилттай болгон ургамлан нөмрөгийг бохирдохоос сэргийлсэн, мөн тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. Дууссан галын хорны баллон ашиглан замын хажуугийн цацруулагчтай тэмдэглэгээ хийсэн.

14. Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хог хаях нэгдсэн цэг байгуулах



Драг, ЭШ6/45, Авто бааз, Ил уурхайн, Уурын зуухны хэсэгт тус бүрт 2 ш хогийн сав байршуулан хог хаягдлыг 7 хоногт бүр төвлөрсөн хогийн цэгт хаяж байна.

15. Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой үрийг орон нутгаас худалдан авах, үрийг түүх



Орон нутгийн онцлогт тохирсон нийт 5000 модыг Бүрэгхангай сумын нийтийн эзэмшлийн талбайд 2026 онд тариалхаар тохиролцсон.

16. Олон салаа зам гаргахгүй байх, уурхайн замд тэмдэгжүүлэлт хийх



Уурхайн машин, техникүүдийг маршрутын дагуу явуулж, олон салаа зам гаргахгүй ажилласан. Мөн ашиглагдахгүй замуудыг хааж орохыг хориглосон тэмдэг хийсэн.

Амьтны аймгийг хамгаалах

17. Уурхайн талбайд мал амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хамгаалалт хашаа хийх

Уурхайн ажилчид хууль зөрчсөн тохиолдолд хулгайн хариуцлага хүлээх асуудлаар сургалт мэдээллийг тогтмол өгөх

Ажилчдын тосгонд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэглэхийг хориглох



Драгийн хуучин катлоноос 60-70 ш загас тороор барьж Туул голын усанд тавьж загас барьсан ажиллагсдыг урамшуулан ажиллаж байна.

Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

18. Улс,аймаг, сум орон нутгийн төсөвт даатгалын шимтгэл төлбөрүүдийг оруулах, нийгмийн хариуцлагын хүрээнд сумын дэд бүтэцийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах



Булган аймгийн Бүрэгхангай сумтай байгуулсан Нийгмийн хариуцлагын хүрээнд 50 сая төгрөгийг сумын төрийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулж ОНХСан-д шилжүүлсэн.

19. Орон нутгийн
ИТХ-ын
тэргүүлэгчдэд
ажлын тайлан жил
бүр тайлагнах



Дэрст баг болон Хайлааст багийн иргэдэд
Байгаль орчин, нөхөн сэргээлтийн
чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг
танилцуулсан.

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Шижир алт” алтны үйлдвэр нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж эхэлснээс бүхий л хугацаанд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар төлөвлөн амжилттайгаар хийж гүйцэтгэн ажиллаж байна. Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

- Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбай
- Овоолгын нөхөн сэргээлт
- Үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт
- Орчны тохижилт

Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт

“Шижир Алт” алтны үйлдвэр нь нийт 11 жилийн хугацаанд 771.13 га эвдэрсэн талбайд тухайлбал 2008 онд 62 га, 2010 онд 11 га, 2012 онд 33.4 га, 2013 онд 13 га, 2014 онд 20 га, 2015 онд 27 га, 2016 онд 29.1 га, 2017 онд 14.1 га, 2018 онд 16.2 га, 2019 онд 24 га, 2020 онд 20 га, 2021 онд 10 га, 2022 онд 8 га, 2023 онд 10 га-д техник, 5 га биологи, 2025 онд 14.33 га-д техник, 6,85 га-д биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Зураг MV-000175 талбайн техникийн нөхөн сэргээлт





Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучсан байдал

Биологийн нөхөн сэргээлт

“Шижир-Алт” АҮ нь 2025 онд Туул голын гольдрол ордын MV-000175 тоот тусгай зөвшөөрлийн 6,85 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.



MV-000175 тоот тусгай зөвшөөрлийн талбайн биологийн нөхөн сэргээлт



Ногоон байгууламж

“Шижир Алт” алтны үйлдвэр Бүрэгхангай сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5000 ширхэг модыг нийлүүлэхээр болсон.



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагаанаас байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай байдаг.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн менежментийн арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго юм.

Булган аймгаас оноож өгсөн Бүрэгхангай сумын Дэрст багийн Сөөгийн дэнжийн 5,4 га талбайд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.

Нөхөн сэргээлт хийхийн өмнө



Нөхөн сэргээлт хийсэн талбай



Нөхөн сэргээлт хийхийн өмнө



Нөхөн сэргээлт хийсэн талбай



Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Туул голын гольдрол”-ын алтны шороон ордын талбайн ойр орчим нөлөөллийн бүст айлын өвөлжөө, хаваржаа бүхий газартай давхцаагүй учир нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох ажил хийгдэхгүй байхаар төлөвлөсөн.

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус ордын талбайд одоогоор энэ төрлийн олдвор олдоогүй. Хэрэв уурхайн эдэлбэр газрын хүрээнд түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентологийн олдвор илэрсэн тохиолдолд сум, аймгийн захиргаанд болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж, зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулна.

**“ТУУЛ ГОЛЫН ГОЛЬДРОЛ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-12 Осол, эрсдэлийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2023 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлт
1	2	3	4	5	6		
1	Үер, газар хөдлөлт, галын аюул	Үерийн уснаас хамгаалсан далан байгуулах, үйлдвэрийн талбайд тэмдэг тэмдэглээ хийж тавих, мал, хүн орохоос хамгаалж хаалт хамгаалалт хийх, эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйлдвэрийн орчинд		Дотоод төлөвлөлтөөр		Төслийн талбайн орчимд далан, шуудуу татаж хүн мал амьтан унаж бэртэхээс сэргийлэн аюулгүй байдлыг хангасан.
2	Болзошгүй аюул осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж Уурхайн ажилчдад Ажилчдын хотхон, ил уурхайн ажлын байранд	1500,0	1500,0	Жилд 1 удаа Үйл ажиллагаа ны туршид	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж байна. Үйлдвэрийн газрын ХАБ, ЭА хариуцсан ерөнхий мэргэжилтэн улирал тутамд үзлэг шалгалт хийж, захирлын тушаал батлуулан хэрэгжилтийг хангуулан ажилладаг. 2023 оны 05 дүгээр сарын 20-ны өдөр Уул уурхайн аврах ангиас нийт 130 ажилчинд галын аюулгүй байдлын сургалт авсан. Гал унтраах хэрэгслүүдийг зохих газруудад байрлуулан ажилласан.
3	Байгалийн гэнэтийн аюулт үзэгдэл	Уурхайн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах	Үерийн уснаас хамгаалах далан байгуулах		Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд орсон.		Төслийн талбайн орчимд далан, шуудуу татаж хүн мал амьтан унаж бэртэхээс сэргийлэн аюулгүй байдлыг хангасан.

БОМТ-ийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт-14

№	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Биелэлт
1	Уурхайн удирдлагын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх Ажилчдад хог хаягдлын талаар сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчид Уурхайн ажилчдад	Байгаль орны аудит хийлгэж, уг тайлангийн зөвлөмжийн дагуу үйлдвэрийн дотоод нөөц бололцоогоо ашиглан байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна. Үйлдвэрийн нийгмийн хариуцлагыг сайжруулах, ажилчид болон нөлөөллийн бүст оршин суугаа ард иргэдэд эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хог хаягдлын менежментийн төсөл хийлгэх зөвлөх үйлчилгээг “Өнгө нэм” ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл нь менежментийн төслийн тайланг боловсруулж, сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэсэн.
		Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн ажилчид	Жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг танилцуулахаар БИНХ-д танилцуулга хийн ажилладаг. Мөн 2023 оны 10 дугаар сард Дэрст багийн иргэдийн нийтийн хуралд төсөл хэлэлцүүлэхээр орохдоо ард иргэдийн санал хүсэлтийг сонсч, уриалга гаргасан.
		Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх.		“Монголросцветмет” ТӨҮГ нь татвар, хураамжуудаа хуулийн дагуу хугацаанд нь төлсөн.
		Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн удирдлага	“Эковишн” ХХК-иар байгаль орчны аудит хийлгэж, биелэлтийг хангаж ажиллаж байна.
		Ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт оруулах	Уурхайн ажилчид	Нийт 120 ажилтныг 2023 онд “Сүрьеэгүй Монгол” мөн улс орон даяар хэрэгжиж буй “Эрт илрүүлэгт” иж бүрэн шинжилгээ үзлэгт хамруулсан.

“ТУУЛ ГОЛЫН ГОЛЬДРОЛ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ нь “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-аас явуулж буй үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж буйг, мөн үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

“Туул голын гольдрол”-ын алтны шороон ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ний тайлан, БОМТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон ОХШХ-т тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг Булган аймгийн итгэмжлэгдсэн лаборатороор 2025 оны 5,10 сард ус, агаар, хөрсний шинжилгээ хийлгэсэн. Мөн БОАЖЯ-ны дэргэдэх Судалгаа шинжилгээний албаны лаборатороор 22 цэгээс ус, агаар, хөрсний шинжилгээ хийлгэсэн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар ойлго
Дээж оруулсан газрын нэр, хааг, утас : ГУ-2025/021
Дээж авсан хүний нэр, албан тушаал : Төв аймаг Засаг сум Шажир Алт АУ
Дээж авсан өдөр : МН-000175 Туул гол гольдрол
Дээж авсан өдөр : 2025.10.22
Дээж авсан өдөр : 2025.10.22
Дээж авсан өдөр : 2025.10.22-10.25
Хуваарь тоо : 171
Үр дүн : 1

№	Усны химийн шинжилгээний үзүүлэлт, нэгж	Шинжилгээний аргачлал	MNS ISO 4484:2004 ЗДХ	Туул голын ус
1	pH-Усны өрчим	MNS ISO 10523:2001	6.5-8.5	6.89
2	Бад-Цах (грамм)	MNS ISO 9484:1999		0.03
3	Жинхэнэ бодас Ойго	MNS 6835:2000		7.6
4	Перманганатын исэлдэх чадар (МН)	MNS 6833:2000		1.5
5	Хатуулга (г/л-эсвэл)	MNS ISO 6059:2005		0.9
6	Кальци (мг/л)	MNS 1097:2003		38.8
7	Магни (мг/л)	MNS 1097:2003		19.4
8	Натри-Кали (мг/л)	MNS 1097:2003		31
9	Хлорид (мг/л)	MNS 4434:2006	300	28.8
10	Натрийн азот NO ₃ -N	MNS 1097:2003	0.2	1.18
11	Натрийн азот NO ₂ -N	MNS 8778:2016	0.02	0.001
12	Аммонийн азот NH ₄ -N	MNS ISO 8467:1999	0.5	0.18
13	Темпер (цельс)	MNS 4430:2002	0.2	0.04
